

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭР БОЛОН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 04 дүгээр сарын 04

Улаанбаатар хот

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад холбогдох заалт, шийдвэрээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланд тулгуурлан Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж дүгнэв.

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

2025 оны нэгдүгээр улирлын байдлаар байгууллагын үндсэн чиг үүрэгт хамааралтай Монгол Улсын хууль, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, хуралдааны тэмдэглэлд тусгагдсан нийт 1 хууль, Улсын Их Хурлын тогтоол 1, Засгийн газрын тогтоол 3, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээс 3, Засгийн газрын албан даалгавар 1, нийт 9 шийдвэрийн 11 зүйл заалтыг хэрэгжүүлэн ажилласныг хяналтад авав. (Хүснэгт 1.)

Дээрх 9 шийдвэрийн нь бүгд “үр дүн гарсан” буюу 100 хувьтай 7 зүйл, заалт, тодорхой үр дүнд хүрсэн буюу 90 хувийн гүйцэтгэлтэй 3 зүйл заалт, 70 хувийн гүйцэтгэлтэй 1 зүйл заалт, байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй буюу үнэлгээнд тооцохгүй 1 зүйл заалт нийлбэр үнэлгээгээр 96.6 хувь үнэлэгдлээ.

Хүснэгт 1.

Шийдвэрийн төрөл						
Бүгд		Монгол Улсын хууль	Улсын Их Хурлын тогтоол	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар
Хяналтад авсан хууль, тогтоол шийдвэрийн тоо		9	1	1	3	3
Заалтын тоо		12	1	1	3	6
ҮНЭЛГЭЭ	Биелсэн (100%)	6	-	-	2	3
	Тодорхой үр дүнд хүрсэн (90%)	4	-	1	1	2

	Хэрэгжих шатанд (70%)	1	1	-	-	-	-
	Үнэлгээнд тооцохгүй	1	-	-	-	1	-

Монгол Улсын хуулийн хэрэгжилтийн хувийг хүснэгтээр илэрхийлбэл:
(Хүснэгт 2.)

№	Зүйл, заалт дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Дундаж хувь
1. Монгол Улсын хууль			
1	18.2. Хил орчмын аялал жуулчлалын нутаг дэвсгэрт энэ хуулийн 18.1-д заасан гадаадын иргэн зорчих маршрутыг хууль зүйн болон аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	Аялал жуулчлалын тухай 2023-05-04 Дугаар 2023.05.04	70

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн хувь (Хүснэгт 3.)

№	Зүйл, заалт дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Дундаж хувь
2. Улсын Их Хурлын тогтоол			
1	ХЗДХЯ УИХ-ын тогтоолын төсөл 2021. Монгол Улсад 2021-2024 онд цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 29.6-д заасны дагуу Монгол Улсад 2021-2024 онд цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлыг тогтоох.	Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай 2021-01-22 Дугаар 2021 №12	90

Монгол Улсын Засгийн Газрын тогтоолын хэрэгжилтийн хувь (Хүснэгт 4.)

№	Зүйл, заалт дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Дундаж хувь
3. Монгол Улсын Засгийн газрын тогтоол			
1	3.Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам")	Журам батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_77	90
2	2..Төрийн байгууллага өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, үүнтэй холбогдсон гомдлыг Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан авч, зөрчил гаргасан албан тушаалтанд хуульд заасан	Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215	100

	үндэслэл, журмын дагуу хариуцлага тооцож байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай		
3	2.2.Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд танилт, нэвтрэлтийн системийг ашиглахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт болон төрийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.	Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай 2024-12-18 2024_217	100

Монгол Улсын Засгийн Газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн хувь.
(Хүснэгт 5.)

№	Зүйл, заалт дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Дундаж хувь
4. Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл			
1	1.2.5.Иргэдийн зорчих нөхцөлийг хөнгөвчлөх талаар БНСУ-ын холбогдох байгууллагатай хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж, энэ хүрээнд дараах асуудлыг хэлэлцэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт: -Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах замаар харилцан нийгмийн даатгалаас чөлөөлөх хугацааг нэмэгдүүлэх, төлөгдсөн нийгмийн даатгалын буцаан олголтод хамаарах визийн ангилал хүрээг нэмэгдүүлэх; -БНСУ-д эмчилгээ хийлгэж буй иргэдийг дэмжих зорилгоор тус улсын эмнэлгүүдийн төлбөрийн хөнгөлөлтийг эдлүүлэх болон эрүүл мэндийн даатгалд хамрагдах; - Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй монгол иргэдийн эцэг, эх, үр хүүхэд, гэр бүлийн зүгээс тус улсад зорчих виз хүсэхэд тодорхой хөнгөлөлт эдлүүлэх.	2023 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2023-02-20 Дугаар 2023_9	90
2	39.29.12.3.Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага кибер аюулгүй байдлыг хангах чиг үүргээ тодорхой албан тушаалтанд хариуцуулж, үйл ажиллагааны болон кибер аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсвийн төсөлд тусгаж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэл 2024-11-13 Дугаар 2024_39	100
3	41.13.2.1.Засгийн газрын 2022 оны 178 дугаар тогтоолоор Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийг Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлсөн хугацааг сунгах асуудлыг судалж, зохих журмын дагуу шаардлагатай арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл нарт;	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэл 2024-11-27 2024_41	100
4	41.22.2.Монгол, Францын хамтарсан Ураны төсөл, зарим хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминал барих ажил болон гадаадын хөрөнгө оруулалттай зарим томоохон төслийн үйл ажиллагаанд тулгараад байгаа татварын маргаан, зөрүүтэй ойлголтыг шуурхай шийдвэрлэх чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол		-

	Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан нарт тус тус		
5	41.13.2.2.Жуулчдад цахим виз олгох журам, шаардлагыг олон улсад сурталчлан таниулах, цахим визийн системд сайжруулалт хийж, бүлэг жуулчдад (8 буюу түүнээс дээш тооны) виз олгох хувилбарыг нэвтрүүлэх арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл нарт;		100
6	41.13.2.3.Хил орчмын аялал жуулчлалын чиглэлд автомашинтай аялах хүсэлтэй жуулчдыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон дотоодын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд чөлөөтэй зорчих боломжийг хангах арга хэмжээ авч ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал)-т;		90

Монгол Улсын Засгийн Газрын албан даалгаварын хэрэгжилтийн хувь.
(Хүснэгт 6.)

№	Зүйл, заалт дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Дундаж хувь
1. Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл			
1	12.5.Төрийн албаны шинэчлэлийг харьяа салбарын хүрээнд манлайлан хууль сахиулах байгууллагын албан хаагчдын сахилга, хариуцлагыг өндөржүүлэх, тус салбар дахь хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсан тай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024-09-18 Дугаар 2024_01_1	100

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт нь дээрх 12 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээ 93.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

2. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт

2.1.Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2025 онд 1 зорилт, 1 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж ажилласан нь үр дүнтэй буюу 100 хувьтай үнэлэгдсэн. (Хүснэгт 7.)

Хүснэгт 7.

№	Бодлогын чиглэл	Зорилтын тоо	Нийт арга хэмжээний тоо	Үүнээс						Хэрэгжилт /хувь/
				100%	90%	70%	50%	30%	0%	
1	Засаглалын бодлого	1	1	1	-	-	-	-	-	100

1.2. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн арга хэмжээний хэрэгжилт:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгагдсан 2 арга хэмжээний хэрэгжилт бүгд 100 хувьтай үнэлэгдсэн байна.

Хүснэгт 9.

№	Зорилго, зорилт	Нийт арга хэмжээний тоо	Үүнээс						Хэрэгжилт /хувь/
			100%	90%	70%	50%	30%	0%	
1	2.7.3.гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалах, хяналт тавих тогтолцоог бэхжүүлнэ.	1	1	-	-	-	-	-	100
2	7.2.4.гадаадын иргэдийг улсын хилээр нэвтрэх үед биеийн давхцахгүй өгөгдлийг авч, нэгдсэн санд бүртгэх тогтолцоог бүрдүүлнэ.	1	1	-	-	-	-	-	100
3	Нийт	2	2	-	-	-	-	-	100

2.3. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд 1 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлсэн нь 100 хувийн биелэлттэй үнэлэгдлээ.

Дүгнэлт, санал

Байгууллагын хэмжээнд Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгийн 2025 оны нэгдүгээр улиралд 4 үзүүлэлтийн 9 хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн 4 арга хэмжээ тус бүр 98.4 хувьтай үнэлэгдлээ.

Хүснэгт 12.

Үзүүлэлт		Үнэлгээ
		I улирал
Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт (Монгол Улсын хууль, УИХ-ын тогтоол, УИХ-ын байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл, ЗГ-ын албан даалгавар)	94.5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	100
	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	100
	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт	100
Ерөнхий үнэлгээ		98.4

Мөн бүрэн хэрэгжсэн, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон дараах шийдвэрийн заалтуудыг хяналтаас хасуулах саналтай байна. Үүнд:

Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл: 41.13.2.1.Засгийн газрын 2022 оны 178 дугаар тогтоолоор Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийг Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлсөн хугацааг сунгах асуудлыг судалж, зохих журмын дагуу шаардлагатай арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл нарт;

Хэрэгжилт: 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 235 дугаар тогтоолоор 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 178 дугаар тогтоолын 1 дэх заалтад өөрчлөлт оруулж, Монгол Улсад 90 хүртэл хоногийн хугацаагаар жуулчлах Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Монгол Улсын визийн чөлөөлсөн. (100 хувь)

Мөн хэрэгжих шатандаа буюу 70 хувийн гүйцэтгэлтэй дараах арга хэмжээний биелэлтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай. Үүнд:

Монгол Улсын хууль: 18.2. Хил орчмын аялал жуулчлалын нутаг дэвсгэрт энэ хуулийн 18.1-д заасан гадаадын иргэн зорчих маршрутыг хууль зүйн болон аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

Хэрэгжилт: “Монголд зочлох жил”-ийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчалын сайдын 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/314 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус байгууллагаас Виз, зөвшөөрлийн газрын дарга ажиллаж, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Журам батлах тухай” 142 дугаар тогтоолоор "Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах журам"-ыг баталсан. Хил орчмын аялал жуулчлалын нутаг дэвсгэрт гадаадын иргэн зорчих маршрут батлагдаагүй байна. Монгол Улсад аялах БНХАУ-ын бүлэг жуулчдын нэрсийн жагсаалтын загварт саналыг 02 дугаар сарын 19-ний өдрийн 02/423 дугаар албан бичгээр Гадаад харилцааны яамны Консулын газарт хүргүүлээд байна. (70 хувь)

Цаашид нийт хууль, тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн чанарт анхаарч, үр дүнг бууруулахгүй, тайланг 2000 тэмдэгтэд багтааж товч, тодорхой тайлагнаж ирүүлж ажиллахыг санал болгож байна.

--oo0oo--